



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 54

Есөнбулаг сум

Дахин дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 77 дугаар 77.2.3 дахь заалт, 77.3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 303 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан авах санал ирээгүй хавсралтад дурдсан 6 барилга, байгууламжийн өмнө тогтоосон үнийг 50 хувиар бууруулан дахин дуудлага худалдааг явуулахыг зөвшөөрсүгэй.


2. Хувьчлагдаж буй өмч хөрөнгийг хувьчлагдах хүртэл хадгалалт, хамгаалалтад нь хяналт тавьж, дахин дуудлагын худалдааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 59 дүгээр тогтоолын хавсралт



50 ХУВЬ БУУРУУЛАН ХУВЬЧЛАХ БАРИЛГЫН ТАНИЛЦУУЛГА

/ төгрөгөөр /

| Д/д | Эзэмшигч байгууллагын нэр | Барилгын нийт талбай /кв.м/ | Ашиглалтанд орсон он | Ашигласан жил | Тоо хэмжээ | Анхны өртөг | Бүгд үнэ | Элэгдэл | Засвар хөрөнгө оруулалт | Үлдэгдэл өртөг | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 19 дүгээр тогтоолоор тогтоосон үнэ | 50% буулган хувьчлахаар тогтоосон үнэ |
|--------------------------------|--|-----------------------------|----------------------|---------------|------------|-------------|-------------|-------------|-------------------------|----------------|---|---------------------------------------|
| Нэг. Барилга байгууламж | | | | | | | | | | | | |
| 1 | Хөхморьт сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилга | 384 | 1981 | 36 | 1 | 135,209,800 | 135,209,800 | 81,125,880 | | 54,083,920 | 27,041,960 | 13,520,980 |
| 2 | Хөхморьт сумын Дунд сургуулийн хуучин дотуур байр | 795 | 1975 | 41 | 1 | 272,383,800 | 272,383,800 | 202,017,985 | | 70,365,815 | 35,182,908 | 17,591,454 |
| 3 | Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилга | 743.4 | 1996 | 21 | 1 | 215,369,010 | 215,369,010 | 66,034,532 | | 147,539,737 | 73,769,868 | 36,884,934 |
| 4 | Бугат сумын Цагдаагийн хэсгийн хуучин кабоны барилга /Хуучин Эрүүл мэндийн төвийн барилгын залгаа/ | 48 | 2008 | 9 | 1 | 26,222,500 | 26,222,500 | 4,151,904 | | 22,070,596 | 11,035,298 | 5,517,649 |
| 5 | Бугат сумын ЗДТГ-ын зочид буудал, гуанзны барилга | 548 | 1967 | 50 | 1 | 153,855,800 | 153,855,800 | 127,999,478 | | 25,856,322 | 12,928,161 | 6,464,081 |

| | | | | | | | | | | | | |
|----------|--|-----|------|----|---|---------------|---------------|-------------|--|-------------|-------------|------------|
| 6 | Шарга сумын ЗДТГ Ахуй үйлчилгээний төв | 990 | 1966 | 51 | 1 | 321,366,000 | 321,366,000 | 272,714,800 | | 48,651,200 | 24,325,600 | 12,162,800 |
| Нийт дүн | | | | | | 1,124,406,910 | 1,124,406,910 | 754,044,579 | | 368,567,590 | 184,283,795 | 92,141,897 |